



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/17

Арвайхээр

Эмч, ажилчдыг коронавируст халдвар (COVID-19)-ын эсрэг вакцинаар дархлаажуулалтанд хамруулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Дархлаажуулалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.2, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/33 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


I. Эмч, ажиллагсдыг коронавируст халдвар (COVID-19)-ын эсрэг вакцинаар дархлаажуулалтанд хамруулсугай.

II. Эмч, ажиллагсдыг коронавируст халдвар (COVID-19)-ын эсрэг вакцинаар дархлаажуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

III. Коронавируст халдвар (COVID-19)ын эсрэг вакцинаар дархлаажуулах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, төлөвлөгөө гарган ажиллахыг Эмчилгээ эрхэлсэн дэд захирал /Д.Мөнхнасан/-д, дархлаажуулах үйл ажиллагаанд эмч, ажилчдыг идэвхитэй хамруулахыг Хүний нөөц, сургалт, хөгжлийн албаны дарга /Л.Алтантөгс/, Сувилахуйн албаны дарга /Ц.Төмөрцоож/ нарт, халдварын эсрэг дэглэмд хяналт тавих, дархлаажуулалтын дараах урвал хүндрэл, эмч, ажиллагсдын цахим бүртгэл хийж ажиллахыг Халдварын сэргийлэлт хяналтын албаны дарга /Г.Надмидсүрэн/-д тус тус үүрэг болгосугай.


IV. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын албаны дарга /Д.Болормаа/-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Э.ХҮДЭРЧУЛУУН

Захирлын 2021 оны 24 дугаар сарын
24-ны өдрийн 44 дугаар
тушаалын хавсралт



Эмч, ажилчдыг коронавируст халдвар (COVID-19)ын эсрэг вакцинаар
дархлаажуулалтанд хамруулах ажлын хэсэг

Ажлын хэсгийн ахлагч : Д.Мөнхнасан (Эмчилгээ эрхэлсэн дэд захирал)
Нарийн бичиг : Г.Надмидсүрэн (Халдварын сэргийлэлт хяналтын албаны дарга)
Гишүүд: Л.Алтантөгс (Хүний нөөц, сургалт, хөгжлийн албаны дарга)
Ц.Төмөрцоож (Сувилахуйн албаны дарга)
Ж.Нарантуяа (Чанарын менежер, арьс харшлын эмч)
Д.Сайнжаргал (Тархвар судлаач)
Б.Цолмонтуяа (Дотрын эмч)
Э.Мөнхцэцэг (аралтай тусламжийн тасгийн эрхлэгч)
Ж.Дэмиддолгор (Халдвартын тасгийн эрхлэгч)
Л.Золзаяа (Яаралтай тусламжийн эмч)
Б.Тогтохбаяр (Эрчимт эмчилгээний эмч)
С.Оюундэлгэр (Вакцинатор сувилагч)
Д.Сүнчинмаа (Вакцинатор сувилагч)
Б.Цэндоо (IT инженер)